



БЛАН-ӨЛГІЙ АЙМАГ
ДЭЛУУН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/69

Рашаант

Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх
тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлалтай 8306000020 нэгж талбарын дугаартай 753м² газар эзэмших эрхийн Асхабыл овогтой Камесийн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар эзэмших эрхийг БЖ98081331 регистрийн дугаартай Харахас Жадик овогт Камес овогтой Иманмагзам-д зориулалтаар нь 12 жилийн хугацаатай, 12 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлалтай 8306001334 нэгж талбарын дугаартай 45м² газар эзэмших эрхийн Шакиран овогтой Хажмуханы үйлчилгээний зориулалттай газар эзэмших эрхийг БЖ95111558 регистрийн дугаартай Молхы Хошах овогт Серикбол овогтой Раймбек-т зориулалтаар нь 12 жилийн хугацаатайгаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2004 оны 01 тоот захирамжийн иргэн А.Камест холбогдох хэсэг, 2022 оны А/69 тоот захирамжийн иргэн Ш.Хажмуханд холбогдох хэсэг газар эзэмших эрхийн 0000067877, 0144252 тоот гэрчилгээнүүдийг тус тус хүчингүй болгосугай.

3. Иргэд К.Иманмагзам, С.Раймбек нартай газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгохыг газрын даамал /Б.Берденбек/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.СЕРИКБОЛ